



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 5/21

Хэрлэн сум

Г.Мөнх-Эрдэнийг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Галсанцэрэнгийн Мөнх-Эрдэнийг 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------|---------------|---|
| Комиссын дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Мөнхжаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн |
| | Б.Баясгалан | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлалын албаны дарга |
| | Л.Түмэнжаргал | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч |
| | З.Буянцэцэг | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн |

3.Г.Мөнх-Эрдэнэд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын үндсэн цалингаас зөрүүг тооцож олгохыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

2.

4.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Мөнх-Эрдэнэд үүрэг болгосугай.

5.Г.Мөнх-Эрдэнэд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ